

Сургалт, судалгаа

Сургалтын технологийг өөрчилж шинэчлэх нь

Манай орон зах зээлийн харилцаанд шилжиж, бүх салбаруудыг хамарсан гүнзгий өөрчлөлт, шинэчлэлт явагдсан билээ. Боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөн шинэчлэх ажлын хүрээнд бүх хичээлүүдийн агуулга, арга зүй, технологийг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор гарч ирсэн юм.

Сургалт гэдэг бол багш, оюутан суралцагчдын хамтын үйл ажиллагааны үр дүнд амжилтанд хүрдэг үйл явц юм. Сургалтын технологи гэдэг нь сургалт хүмүүжлийн ажлыг явуулах, зохион байгуулах ур чадвар, заах арга, барил юм.

Сургалтын технологийг өөрчлөн шинэчлэх талаар олон эрдэмтэн мэргэд өөрсдийнхөө санал, бодол, дүгнэлтийг гаргаж ирсэн байна.

Үүнээс авч үзье.

1. Японы эрдэмтэн, сурган хүмүүжүүлэгч Т.Сакамото "Сургалтын технологи гэдэг бол анги дахь сургалтыг системчлэх аргыг сурган хүмүүжүүлэх ухаанд нэвтрүүлэх явдал" гэж үзсэн байдаг.

2. Доктор, профессор Ч.Лхагважав "Сургалт бол өөрчлөлт хийх үйл ажиллагааны зохион байгуулалт арга хэрэгсэл юм" гээд "Сургалтын технологи гэдэг бол өөрчлөлтийн явцыг зохион байгуулах соёл, ур чадвар, ухаан, арга зам хэмээн ойлгож болно" гэж бичжээ.

ХИЛ СУДЛАЛ

Сургалтын технологийг судлаачид дотор нь 3 хэсэгт хуваан авч үзсэн байна.

Үүнд:

1. Орц
2. Чанарын хувиргалтын үйл явц
3. Гарц

Орц гэдэг ухагдахуунд суралцагчдын урьд нь эзэмшсэн тодорхой мэдлэг, дадлага, хандлагыг авч үздэг.


Чанарын хувиргалтын үйл явцыг дотор нь:

- а. Сургалтын өмнөх үеийн
- б. Сургалтын үеийн
- в. Сургалтын дараах үеийн үйл ажиллагаа бөгөөд эдгээр үйл ажиллагааны аргачлал, техник буюу ур чадвар, арга барил юм.

Гарц гэдэг ухагдахуунд тухайн хичээлээр эзэмшсэн мэдлэг, дадлага, хандлагыг хамааруулна. Багш бүр явуулах үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг сайтар боловсруулах шаардлагатай. Сургалтын технологийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, өөрийн гэсэн заах арга барил, ур чадвартай байх хэрэгтэй.

3. Сургалтын технологийг өөрчлөнө гэдэг бол мэдлэг, чадвар, дадлага эзэмшүүлэх үйл ажиллагааны эцсийн үр дүнг тооцох явдал юм. Энэ талаар АНУ-ын сэтгэл зүйч Д.Кэрол, Б.Блум нар “Бүрэн эзэмшүүлэх горим” гэдгийг боловсруулсан. Энэ нь суралцагчдын сурах байдалд муу, ердийн, авъяастай гэсэн ангилал хийж, сургалтын ажлаа нөхцөл байдал, хугацаа, хурд өөр өөрийн боловч “үр дүн нь ижил байх” оновчтой хувилбарыг боловсруулж хэрэгжүүлсэн. Энэ нь сурагцагчдын сэтгэц, танин мэдэх үйл ажиллагааны онцлог байдлыг харгалзан үзэж, гурван чиглэлээр хуваан ганцаарчлан ажиллаж, сургалтын эцсийн үр дүнд амжилтанд хүрнэ гэсэн үг юм.

4. Дээрхи эрдэмтдийн дүгнэлт, уламжлалт сургалтын аргад үндэслэн дэд доктор, профессор Д.Ванчинсүрэн “Сэтгэхүйн үйлдлийг төлөвшүүлэх хичээлийн технологи” гэдэг сургалтын технологийн шинэ хувилбарыг боловсруулсанг юм. Үүнийг товч авч үзвэл:



1. **Маргаан ярилцлага.** Багш суралцагчид харилцан асуулт тавьж ярилцлага, маргаан явуулж, нэг үгээр хэлэхэд ном хаялцана. Асуулт, хариулт нь задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, хариуцуулах, оюуны дүгнэлт хийх, сэтгэхүйн үйлдлүүдийг шаардсан байвал илүү үр дүнд хүрнэ.

2. **Багш, суралцагчдын нэмэлт мэдээлэл.** Багш, суралцагчдын нэмэлт мэдээлэлийг дотор нь 2 ангилж авч үзэж болно. Үүнд:

А. Багшийн мэдээлэл

Б. Суралцагчдын мэдээлэл

А. Багшийн мэдээлэл товч, оновчтой, сурагцагчдын танин мэдэх оюуны хэрэгцээг хангахуйц хөгжүүлэх зорилготой.

Б. Суралцагчид мэдээлэлийнхээ эх сурвалжийг өөрсдөө эрэлхийлж, өмнөх хичээлийн явцад эзэмшсэн тулгуур ухагдахуунийг ашиглан өөрсдийн санал бодлоо илэрхийлэх, бие даасан оюун дүгнэлт гаргах, боломж олгох, марган хэлэлцэх, нотлон эзэмшүүлэх, соёл эзэмшүүлэх давуу талтай.

3. **Урьдчилан мэдээлэх.** Тухайн сэдвийг заахад мэргэжлийн талаар өндөр мэдлэг, чадварыг шаарддаг. Сэдвийн гол ухагдахууны мэдээлэл нь дараагийн хичээлээр судлах сэдвийн тулгуур ухагдахууны агуулгаар нь ойлгуулна.

4. **Бие даасан ажил.** Бие даасан ажил нь ангид ба гэрт гэсэн хоёр хэсэгт хуваагдах ба харьцуулах, ерөнхийлөн дүгнэх, задлан шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэх, оюун дүгнэлтийг гаргана. Багш хамгийн сүүлд нь хичээлээ дүгнэнэ.

5. Ээлжит хичээлдээ бэлтгэхдээ оюутнуудын танин мэдэх үйл ажиллагааны онцлог байдал, түвшинг харгалзан үзэх шаардлагатай

ХИЛ СУДЛАЛ

байдаг. Оросын эрдэмтэн Л.С.Выготский, С.Л.Рубенштейн, А.Н.Льонтев, Д.Б.Эльконин нар "Оюуны үйлийг шатлан төлөвшүүлэх онол" гэдгийг боловсруулсан юм. Оюутан суралцагчдын гадаад, дотоод үйл ажиллагааны холбоо анхаарал нь сэтгэцийн шинэ бүрдэл болон төлөвшдөг. Багш сурган хүмүүжүүлэгчид суралцагчдынхаа сайн талыг түшиглэн ганцаарчлан ажиллавал сургалт хүмүүжлийн үр дүн дээшилж, тэдэнд мэдлэг чадвар, дадал төлөвшинө.

Дүгнэлт

Боловсролын агуулгын өөрчлөлттэй холбоотойгоор сургалтын технологид нэлээд өөрчлөлт гарлаа.

1. Лекцийн хэлбэрээс зөвлөх, сургах арга технологи эзэмшүүлэх хэлбэрт илүүтэй анхаарах боллоо.
2. Ном, цаас, үзэгний оронд компьютер, техник хэрэгсэл ихээр ашиглах боллоо.
3. Суралцагчдын өөрийнх нь идэвхитэй үйл ажиллагаанд түшиглэх болж байна.
4. Хичээл гэдэг нь багш оюутантай, оюутан нь багштайгаа хамтарч ажиллах, суралцах орчин болж байна.
5. Боловсрол судлалын шинжлэх ухаанд "Багш гэдэг бол суралцагчдын багш байхаас гадна зөвлөгч, туслагч, арга зүйч, инженер, сурган хүмүүжүүлэгч байх ёстой" гэж тодорхойлох болов.
6. Оюутан сурагчдын бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх, уян хатан бүтэцтэй сургалтын технологийг боловсруулж, хичээлдээ хэрэглэхийг шаардаж байна.
7. Сургалтын процессийг эрчимжүүлэн "оновчтой болгох", бага хүч, цаг, материал зарцуулж хамгийн дээд үр дүнд хүрэх технологи боловсруулах нь маш чухал болж байна.

Сонсогч оюутнуудын сэтгэл зүйн төлөвшилтийн асуудалд

Сонсогч оюутнуудыг сэтгэл зүйн хувьд төлөвшүүлж мэргэжлийн чадвартай боловсон хүчин болгож хүмүүжүүлэх асуудалд иж бүрэн

хандах нь өнөөдрийн сургалт хүмүүжлийн ажлын үндсэн зорилтын нэг билээ.

Сургалтын ажлын агуулга, түүний үйл ажиллагааны үр дүн, суралцагчдын сэтгэл зүйн чанар, боловсрол, танин мэдэх үйл ажиллагаа, сэдэл, тэмүүлэл, авъяас, сонирхол зэрэг нь тэдний мэргэжилд нь эзэн болгон төлөвшүүлдэг.

Хилчний мэргэжилдээ дур сонирхолтой болж, өргөсөн тангарагтаа үнэнч, сэтгэлийн тэнхээтэй байж, эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт шударгаар ажиллах нь сонсогч, оюутнуудын сэтгэл зүйн төлөвшлийн асуудлаас ихээхэн шалтгаална.

Сонсогч, оюутнуудын танин мэдэх үйл ажиллагаа, сонирхол, хүсэл тэмүүлэл нь тэдний сэтгэцийн чадвараас шалтгаалж янз бүр байдаг.

Багшийн заасан хичээлийн материал, шинэ ухагдахууныг тайлбарласныг янз янзаар тусган хүлээн авдаг. Жишээ нь: сурагцагчдын ихэнх нь хичээлийн шинэ материалыг тэр дор нь ойлгож ухаардаг. Харин зарим нэг нь хэд дахин хэлүүлж байж сая ойлгох бөгөөд хичээлийн шинэ ухагдахуун, даалгавар бүрийн тоолонгоор сандарч тэвдэж, хооронд нь хольж хутгаж хариулдаг.

Сонсогч, оюутнуудыг сэтгэл зүйн шинж байдлаар тодорхойлох гэдэг нь тэднийг сурган хүмүүжүүлэх, сэтгэл судлалын талаас нь судалж, сэтгэл зүйн онцлогийг нарийн сайн судалж мэдэхийг хэлж байгаа юм.

Сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал нь XIX зууны эхэн хагаст үүссэн бөгөөд түүнийг үндэслэгч нь Оросын эрдэмтэн К.Д.Ушинский юм.

Сүүлийн үед сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал нь суралцагчдын сурган хүмүүжүүлэх ажлын сэтгэл зүйг голлон судалж байна. Сургалтын үйл явцыг шинжлэх ухааны үндэстэйгээр удирдан зохион байгуулах явдал суралцагчдын танин мэдэх үйл ажиллагаа, сэдэл, тэмүүлэл, сонирхол, хэрэгцээг тасралтгүй өрнүүлсэн байх нөхцөл боломжийг бүрдүүлэх арга барилыг эрж хайж судлан

ХИЛ СУДЛАЛ

илрүүлэхэд чиглэгдсэн байна. Мөн бие хүний хөгжил, төлөвшилтийн үйл явцыг судлаачид олон талаас нь судалж тодорхой үечлэн авч үзжээ. Ж.Пиаж (Швецарь), А.Валлон (Англи), Э.Эриксон (АНУ), П.П. Блонский, Д.Б.Эльконин (Орос) нарын үечлэл нэлээд түгээмэл өргөн дэлгэрсэн байна.

Оюутны бие хүн болон төлөвших үйл явц нь ирээдүйн мэргэжилтэй боловсон хүчин болоход маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Суралцагчдын сэтгэл зүйн төлөвшлийн түвшин нь тэдний сурлага, хүмүүжил, аливаа зүйлд хандах хандлагаар илэрнэ. Өөрөөр хэлбэл тухайн хүний боловсролын түвшин түүнийг тодорхойлж өгдөг.

Бие хүний төлөвшлийн үндсэн чиглэл, бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн агуулгыг цогц байдлаар хэрэглэдэг. Бие хүний төлөвшлийн чиглэл, түүний зорилго, агуулгыг уламжлалт сурган хүмүүүүлэх ухаанд олон талаас нь нарийвчлан судалж онол арга зүйн үндсийг боловсруулсан бөгөөд энэ нь:

- Бие бялдарын өсөлт хөгжил, эрүүл аж төрөх, амьдрах соёлыг төлөвшүүлэх,

- Оюун ухааны хөгжил, төлөвшил

- Хөдөлмөрт зүй ёсоор хандах, хөдөлмөрөө үр ашигтай зохион байгуулах чадвар дадал эзэмшүүлэх

- Эдийн засгийн боловсрол

- Ёс суртахууны төлөвшил

- Эрх зүйн боловсрол

- Гоо зүйн боловсрол

- Экологийн боловсрол гэх мэт.

Сонсогч, оюутнуудын сэтгэцийн хөгжил, төлөвшилт нь сургалт хүмүүжлийн аулын явцад төлөвшин сайжирч мэргэжилдээ хандах зөв хэв шинжийг бүрдүүлж сэтгэл зүйн чадварт өөрчлөлт оруулдаг билээ.

Сонсогч, оюутнуудын сэтгэцийн хөгжил, төлөвшилд нөлөөлөх хүчин зүйлүүдийг дараах гурван хэсэгт хувааж авч үзвэл, энэ нь:

1.Сэтгэцийн онцлог чанар

2.Гадаад байдлаараа илрэх үйл ажиллагаа

3. Дотоод хөдөлгөгч хүчний үйл ажиллагаа ... болж байна.

1. **Сэтгэцийн онцлог чанар:** Сонсогч, оюутнуудад шилдэг зан чанар төлөвшихөд сургалт хүмүүжлийн олон талт сонирхол татахуйц ажлууд тэдний сэтгэцийн онцлогийг харгалзан ажиллах зайлшгүй шаардлагатай билээ.

Сэтгэцийн онцлог шинж чанарт:

- Сэтгэл хөдлөл
- Зориг
- Авъяас билэг
- Темперамент
- Зан төлөв ... зэргийг багтаан авч үзэж болно.

2. Гадаад үйл ажиллагаа. Гадаад байдлаараа илрэн гарах үйл ажиллагаанд:

- Харилцааны соёл
- Суралцах арга барилд сурах
- Ном, сурах бичигтэй ажиллаж сурах
- Уран ярих чадварт суралцах
- Ажигч, гярхай зан чанарт суралцах
- Тогтоох арга барилд суралцах
- Бие даасан үйл ажиллагаанд суралцах
- Сэтгэлийн тэнхээтэй, тэвчээртэй, хатуужилтай байх
- Хүний хэлж, ярьж байгааг хүлээцтэй сонсож сурах
- Өөрийнхөө бодол, саналаа товч тодорхой, оновчтой илэрхийлж сурах ... зэргийг хамааруулж байна.

Дээрхи үйл ажиллагаануудаас “тогтоох арга”, “харилцаа” хоёрын тухай товч өгүүлэе.

Жишээ : Тогтоох арга

Тогтоох арга гэдэг нь “Хүн ой ухаандаа ямар нэгэн зүйлийг эмх цэгцтэй хүлээн авах үйл явц юм”. Тогтоох аргыг ой ухаанд буух хэлбэр шинж байдлаар нь:

А. Зориудын

Б. Зориудын биш ой тогтоолт гэж хуваадаг.

ХИЛ СУДЛАЛ

Зориудаар тогтоох аргыг ухамсартай ба цээжлэх гэж хоёр хуваан авч үздэг.

А. Ухамсартай тогтоох гэдэг бол агуулга, учир шалтгааныг олох дотоод логик, холбоон дээр тулгуурлана.

Б. Цээжлэн тогтоох нь материалын гадаад холбоос дээр тулгуурлан олон давтах явцад бий болдог.

Эрдэмтэд, судлаачид “Хүн ой ухаанаа бүрэн сайн ашиглаж чадвал жар хүртэл наслахдаа гурван дээд сургууль төгсөж, зургаан гадаад хэл эзэмшиж, нэвтэрхий толь бичгээс 100,000 өгүүллэгийг тогтоож чадна” гэж тооцоолжээ.

Харилцаа. Харилцаа нь хүнийг төлөвшүүлэх, түүний зан үйлийг өөрчлөх нэг чухал нөхцөл юм. Бусадтай холбоо тогтоох, өөрийгөө бусдад ойлгуулах, батлаж харуулах боломжийг харилцаа хүнд олгодог.

Харилцааг дам ба шууд, ганцаарчилсан ба хэсэг бүлэг олон нийтийн харилцаа гэх зэргээр олон төрөлд ангилж болно.

Харилцааны төрлүүдийг ерөнхийд нь 3 хэв шинжид хувааж үздэг. Энэ нь:

- Захиран тушаах маягийн
- Овжин, аргалсан шинжтэй
- Харилцан ижил тэгш буюу хүмүүжүүлэгч ... гэх

мэтээр томъёологдоно.


3. Дотоод үйл ажиллагаа. Дотоод хөдөлгөгч хүчний үйл ажиллагаанд:

- Сэрэл
- Хүртэхүй
- Ой тогтоолт
- Сэтгэхүй
- Зохион бодохуй (төсөөлөл)
- Анхаарал
- Хэл яриа ... гэх мэтийг багтаадаг.

Эдгээрийн дотроос хэл ярианы тухай товч өгүүлэхэд хэл ярианы хөгжил, ярих чадвар, дадлага дараах 4 шинж чанараар илрэн гардаг. Үүнд:

- Ойлгожтой байх
- Уран тод байх
- Нөлөөлөх хүчин чадалтай, жишээ баримт сайтай байх
- Агуулгыг тодорхой гаргаж ярих ... зэргийг хамааруулна.

Сонсогч, оюутнуудын сурч хүмүүжих үйл ажиллагаа, хүмүүстэй харьцах ёс зүй, бие даасан бүтээлч санаачлага зэрэг сэтгэл зүйн төлөвшлийн асуудалд задлан шинжилгээ хийж үзвэл :



ХИЛ СУДЛАЛ

Ийнхүү хэн болох, хэрхэн яаж сурч, хүмүүжиж, боловсрох, улс эх орондоо мэргэжилтэй боловсон хүчин болох нь сонсогч оюутнуудын өөрийгөө хүмүүжүүлэх үйл ажиллагааны үр дүнгээс ихээхэн шалтгаална.

Өөрийгөө хөгжүүлэх нь бусдыг хүмүүжүүлэхээс ч илүү ухаан шаарддаг. Өөрийгөө судалж, шинжилж үнэлэх явцад өөрийн тухай үзэл, өөрийгөө хүмүүжүүлэх санаа, бодол боловсордог. Өөрийн хүмүүжил гэдэг нь нийгэмч чанар, төрөх төлвөө боловсруулах үйл явц юм. Энд өөрийн чин зориг хатуу тэвчээр чухал юм.

*“Эзэн хичээвэл
Заяа хичээнэ”*

гэдэг Монгол ардын цэцэн үгийг санаж, сонсогч, оюутнууд өөрийнхөө сэтгэцийн хөгжил, мэдлэг, чадвар, дадлагыг хөгжүүлж, бүтээлчээр ажиллаж шаардлагатай байна.

*ХЦДС-ийн ЭШТ-ийн ажилтан,
докторант Б.Эрдэнэ – Очир.*